

**БЮЛАК**  
**BEAULUCK** ビューラック

**ХЭРЭГЛЭХ ЗААЛТ**

Өтгөн хаталтын үед гардаг дараах шинж тэмдгүүдийг намдаана:

Толгой хүнд оргих, нүүрэн дээр юм гарах, бэржийх, арьс загатнах, хоолны дуршил буурах, гэдэс дүүрэх, гэдэсний үйл ажиллагаа хямрах, ходоод мэдрэмтгий болох, хоол боловсруулалт өөрчлөгдөх мөн шамбарам өвчний үед өтгөн гадагшлалтыг түргэсгэнэ.

**НАЙРЛАГА**

<b>Идэвхтэй бодис</b> 3 ширхэг шахмал (өдрийн тун)	Бисакодил .....	15мг
<b>Туслах бодис</b>	Лактозын гидрат, эрдэнэ шишийн цардуул, гидроксипропил целлюлоз, кросповидон, метакрилийн хүчил сополимер LD, триэтил цитрат, тальк, цэвэршүүлсэн чихэр, нунтаг хуайс, желатин, тунадасжсан кальцийн карбонат, титаний исэл, макрогол, кармелоз натри, карнауба вакс, магни стеарат, хүнсний улаан өнгө оруулагч № 3.	

Нэг удаагийн тунг унтахын өмнө зажлахгүйгээр залгиж хэрэглэнэ.

Нас	Нэг удаагийн тун	Өдрийн тунгийн тоо
Насанд хүрэгчид (15 наснаас дээш)	2~3 шахмал	1 удаа
11-14 насны хүүхэд	1~2 шахмал	1 удаа
11-с доош нас	Эмийг хэрэглэж болохгүй	

**ФАРМАКОЛОГИЙН ҮЙЛДЭЛ**

Бюлак нь бүдүүн гэдэсний салст бүрхэвч хүчтэй өвдөх үед өвдөлт намдаах, ходоод гэдсийг цэвэрлэх үйлдэлтэй эм бөгөөд бүдүүн гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөнийг идэвхжүүлэх тул унтахаас өмнө хэрэглэхэд маргааш өглөө нь өтгөн гадагшлахад хялбар болно.

**ТУН БОЛОН ХЭРЭГЛЭЭНИЙ БОЛГООМЖЛОЛ**

- (1) Тун ба хэрэглэх аргыг мөрдөнө.
- (2) Эцэг эхийн хяналтан дор хүүхдэд уг эмийг хэрэглүүлнэ.
- (3) Бюлак нь бүрхүүлтэй шахмал учраас шахмалыг зажлахгүй, бүрхүүлийг гэмтээхгүйгээр бага хэмжээний усаар даруулж, залгиж хэрэглэнэ.
- (4) Антацид болон сүү, сүүн бүтээгдэхүүн ууж, хэрэглэсний дараах 1 цагийн дотор уг эмийг хэрэглэж үл болно.

**БОЛГООМЖЛОЛ**

Эмийн гаж нөлөөнөөс зайлсхийх, өвчний шинж тэмдэг хүндрэхээс сэргийлэхийн тулд доорхи болгоомжлолыг чанд мөрдөх шаардлагатай.

- (1) Уг эмийг хэрэглэж байх үед бусад төрлийн өтгөн шингэрүүлэх эм, бүтээгдэхүүнийг хавсарч хэрэглэхгүй.
- (2) Өдрийн тунг хэтрүүлэн хэрэглэж үл болно.

# KOKANDO PHARMACEUTICAL CO.,LTD. JAPAN

## Дараах хүмүүс эмчээс зөвлөгөө авна.

- (1) Ямарваа нэгэн эмчилгээ хийлгэж байгаа хүмүүс.
- (2) Жирэмсэн буюу жирэмсэн байх магадлалтай эмэгтэйчүүд.
- (3) Гэдэс хүчтэй өвдөж, дотор муухай оргиж, бөөлжилт өгч байгаа хүмүүс.

## Дараах шинж тэмдэгүүд илэрвэл эмийг уухаа зогсоож, эмчээс зөвлөгөө авна.

- (1) Уг эмийг уусны дараа дараах шинж тэмдэг илэрсэн нөхцөлд.

Байршил	Шинж тэмдэг
Хоол боловсруулах эрхтэн тогтолцоо	Хэвлий хүчтэй өвдөх, дотор муухай оргих, бөөлжилт өгч байх үед.

- (2) Уг эмийг хэрэглээд нэг долоо хоног өнгөрөхөд өтгөн хатсан хэвээр байх үед.

\* Өтгөн хэт шингэрэн гүйлгэлт зогсохгүй нөхцөлд уг эмийг хэрэглэхээ зогсоон эмч эсвэл эм зүйчээс зөвлөгөө авах шаардлагатай.

## ХАДГАЛАЛТЫН АНХААРУУЛГА

- (1) Нарны шууд тусгалаас хол, чийггүй, сэрүүн нөхцөлд хадгална.
- (2) Бага насны хүүхдээс хол байлгана.
- (3) Эмийн чанарыг хадгалахын тулд өөр хайрцаг саванд шилжүүлж савлахгүй байх нь зүйтэй.

### Үйлдвэрлэгч ба Түгээгч:

**KOKANDO PHARMACEUTICAL CO., LTD.**

8-27, Nagasuhondori 2-Chome Amagasaki shi, Hyogo ken  
JAPAN

### Албан ёсны эрхтэй нийлүүлэгч:

**АЯЛУУНФАРМ ЭХНБ** Улаанбаатар, МОНГОЛ УЛС

Веб хуудас:

[www.ayaluunpharm.mn](http://www.ayaluunpharm.mn)

Facebook хаяг:

[fb/Ayaluunpharm](https://www.facebook.com/Ayaluunpharm)

Утас:

7000-3839; 7017-3839